

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны  
2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ОРА-2022 /6/НА-СТА-ОНӨААН**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Эрдэнэт хот  
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: [narmandakhts@audit.gov.mn](mailto:narmandakhts@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Эрдэнэ  
Утас: 70355805 Цахим хаяг: [erdeneb@audit.gov.mn](mailto:erdeneb@audit.gov.mn)

Аудитор: Б.Бямбатогтох  
Утас: 70350757 Цахим  
хаяг: [byambagtogtokhb@audit.gov.mn](mailto:byambagtogtokhb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	6
3. Аудитын тайлан .....	8
3.1 Ерөнхий зүйл .....	8
3.2 Дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	9
4.1 Байгууллагын үйл ажилагаа .....	9
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	9
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
8. Аудитын илрүүлэлт.....	13
8.4 Зөвлөмж.....	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	0

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.Аудитын санал дүгнэлт

 <b>ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Урт булаг баг, Ханддоржийн гудамж, Утас/Факс: 70359826 Цахим шуудан: orkhon@audit.gov.mn <i>2022.03.15</i> № <i>108</i> танай _____ -ны № _____ -т	<b>ЭРДЭНЭТ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНГИЙН АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ЗАХИРГААНЫ ДАРГА М.ЭНХБАТ ТАНАА</b>
<b>Хараат бус аудиторын тайлан</b>	
<b>Зөрчилгүй дүгнэлт</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
<b>Дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
<b>Аудитын гол асуудлууд</b>	
<p>Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.</p>	
<p>D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc</p>	

### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Орхон аймгийн хамтын ажиллагааны хүрээнд гэрээ байгуулан тус цэцэрлэгт хүрээлэнг барьж байгуулж байгаа бөгөөд тус гэрээ нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны дарга нь жил бүр аймгийн Засаг даргатай контракт байгуулж ажилладаг бөгөөд 2021 оны контрактын биелэлтээр 95 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэгэн төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлээгүй бэлтгэхэд шаардлагатай гэ үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илэрхийлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10,525.20	13,063.42
1.1.6	Бараа материал	402,100.00	345,900.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	1,793,200.00	7,370,000.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,205,825.20</b>	<b>7,728,963.42</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,834,560,784.37	4,631,169,524.37
1.2.2	Биет бус хөрөнгө	1,200,000.00	1,200,000.00
1.2.9	Хуримтлагдсан элэгдэл	(157,673,211.64)	(408,727,990.24)
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>3,678,087,572.73</b>	<b>4,223,641,534.13</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,680,293,397.93</b>	<b>4,231,370,497.55</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>3,830,833,848.01</b>	4,649,787,715.75
2.3.1	Өмч : а) төрийн	3,830,833,848.01	4,649,787,715.75
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)		(267,876,768.12)
2.3.10	Өмнөх үеийн үр дүн	(150,540,450.08)	(150,540,450.08)
<b>2.3.11</b>	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>3,830,833,848.01</b>	<b>4,231,370,497.55</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,830,833,848.01</b>	<b>4,231,370,497.55</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого /цэвэр/</b>		
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>		-
<b>5</b>	<b>Хүүний орлого</b>	1,079.20	
<b>6</b>	<b>Туслах үйл ажиллагааны орлого</b>	78,255,148.00	164,588,900.00
<b>7</b>	<b>Бусад орлого</b>		6,793,500.00
<b>8</b>	<b>Бусад орлого</b>	-	3,537,000.00
<b>9</b>	<b>Борлуулалт маркетингийн зардал</b>	-	
<b>10</b>	<b>Ерөнхий ба удирдлагын зардал</b>	65,299,822.86	122,784,147.59
<b>11</b>	<b>Санхүүгийн зардал</b>	8,215,879.14	45,712,114.19
<b>12</b>	<b>Бусад зардал /элэгдлийн зардал/</b>	155,280,975.28	237,224,654.40
<b>14</b>	<b>Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/</b>		(37,075,251.94)
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(150,540,450.08)</b>	<b>(267,876,768.12)</b>
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(150,540,450.08)</b>	<b>(267,876,768.12)</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараахт ашиг /алдагдал/</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(150,540,450.08)</b>	<b>(267,876,768.12)</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>		
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

				/төгрөгөөр/
№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг алдагдал	Нийт дүн
<b>1</b>	<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,216,103,254.29</b>	(2,226,936.36)	<b>2,213,876,317.93</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		2,226,936.36	<b>2,226,936.36</b>
<b>3</b>	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,216,103,254.29</b>	-	<b>2,216,103,254.29</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(150,540,450.08)	<b>(150,540,450.08)</b>
5	Бусад дэлгэрэнгүй орлого			-
6	Өмчид гарсан өөрчлөлт	1,614,730,593.72		<b>1,614,730,593.72</b>
<b>9</b>	<b>2020 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b>3,830,833,848.01</b>	<b>(150,540,450.08)</b>	<b>3,680,293,397.93</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-
<b>11</b>	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>3,830,833,848.01</b>	<b>(150,540,450.08)</b>	<b>3,680,293,397.93</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(267,876,768.12)	<b>(267,876,768.12)</b>
13	Бусад дэлгэрэнгүй орлого			-
14	Өмчид гарсан өөрчлөлт	818,953,867.74		<b>818,953,867.74</b>
<b>17</b>	<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>4,649,787,715.75</b>	<b>(418,417,218.20)</b>	<b>4,231,370,497.55</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>78,256,227.20</b>	<b>168,125,900.00</b>
	Татаас санхүүжилтийн орлого	78,255,148.00	164,588,900.00
	Бусад мөнгөн орлого	1,079.20	3,537,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>78,254,802.00</b>	<b>168,123,361.78</b>
	Ажилчдад төлсөн	58,485,334.00	110,400,495.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	6,814,488.86	13,583,652.59
	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	6,170,050.00	14,672,791.00
	бичиг хэргийн зардал	754,100.00	1,962,300.00
	Ашиглалтын зардалд төлсөн	4,960,421.22	20,888,643.19
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	600,000.00	4,737,000.00
	Бусад мөнгөн зарлага	470,407.92	1,878,480.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,425.20</b>	<b>2,538.22</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		

5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,425.20	2,538.22
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,100.00	10,525.20
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,525.20	13,063.42

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмж их нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	төгрөг	<b>57,990,034.00</b>	<b>112,558,000.00</b>	<b>109,200,495.00</b>	<b>3,357,505.00</b>	<b>97.02</b>
	Үндсэн цалин	төгрөг	57,990,034.00	102,325,200.00	95,346,092.00	6,979,108.00	<b>93.18</b>
	Нэмэгдэл	төгрөг		10,232,800.00	13,854,403.00	(3,621,603.00)	<b>135.39</b>
2	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд талах шимтгэл</b>	төгрөг	<b>6,814,488.86</b>	<b>15,195,400.00</b>	<b>13,583,652.59</b>	<b>1,611,747.41</b>	<b>89.39</b>
	Тэтгэврийн даатгал	төгрөг	5,098,885.62	10,693,000.00	9,576,306.48	1,116,693.52	<b>89.56</b>
	Тэтгэмжийн даатгал	төгрөг	537,468.57	1,125,600.00	1,072,292.51	53,307.49	<b>95.26</b>
	ҮОМШө-ний даатгал	төгрөг	429,974.99	900,500.00	857,837.16	42,662.84	<b>95.26</b>
	Ажилгүйдлийн даатгал	төгрөг	52,515.84	225,100.00	188,837.78	36,262.22	<b>83.89</b>
	Эрүүл мэндийн даатгал	төгрөг	695,643.84	2,251,200.00	1,888,378.66	362,821.34	<b>83.88</b>
3	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	төгрөг	<b>13,450,279.14</b>	<b>51,655,700.00</b>	<b>48,595,714.19</b>	<b>3,059,985.81</b>	<b>94.08</b>
	Гэрэл, цахилгаан	төгрөг	4,909,821.22	28,103,500.00	23,812,937.92	4,290,562.08	<b>84.73</b>
	Цэвэр, бохир ус	төгрөг	50,600.00	1,518,000.00	1,373,200.00	144,800.00	<b>90.46</b>
	Байрны түрээс	төгрөг			1,350,000.00	(1,350,000.00)	
	Бичиг хэрэг	төгрөг	754,100.00	722,500.00	1,962,300.00	(1,239,800.00)	<b>271.60</b>
	Тээвэр, шатахуун	төгрөг	600,000.00	1,200,000.00	1,200,000.00	-	<b>100.00</b>
	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	төгрөг	55,000.00	960,000.00	589,005.27	370,994.73	<b>61.35</b>
	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	төгрөг	384,000.00	2,304,000.00	557,000.00	1,747,000.00	<b>24.18</b>
	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	төгрөг	1,329,050.00	8,280,000.00	8,803,291.00	(523,291.00)	<b>106.32</b>
	Нормын хувцас, зөөлөн эдлэл	төгрөг		2,404,500.00	2,404,500.00	-	<b>100.00</b>
	Багаж, техник, хэрэгсэл	төгрөг	2,098,500.00	1,329,200.00	2,040,000.00	(710,800.00)	<b>153.48</b>

Орхон аймгийн Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	төгрөг	1,542,500.00	1,764,000.00	1,425,000.00	339,000.00	<b>80.78</b>
Дотоод албан томилолт	төгрөг		500,000.00	500,000.00	-	<b>100.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгэ	төгрөг	1,200,000.00	600,000.00	1,319,540.00	(719,540.00)	<b>219.92</b>
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	төгрөг	-	720,000.00	-	720,000.00	-
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураам	төгрөг	31,407.92	50,000.00	58,940.00	(8,940.00)	<b>117.88</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	төгрөг	495,300.00	1,200,000.00	1,200,000.00	-	<b>100.00</b>
<b>Нийт</b>		<b>78,254,802.00</b>	<b>179,409,100.00</b>	<b>171,379,861.78</b>	<b>8,029,238.22</b>	<b>95.52</b>
<b>ОНХО-аас санхүүжсэн дүн</b>						
Урсгал засвар /ЗД-аас машин засварт/	төгрөг			3,537,000.00		

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 25-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Бямбатогтох гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны 2021 оны санхүүгийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 04 албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Дотоод хяналт**

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн. Тус байгууллага нь дотоод хяналтын нэгжгүй байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 179,409.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,691.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4. Санхүүгийн тайлангийн тодруулга**

### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны зорилго нь эко ногоон бүс бий болгох, Эрдэнэтийн иргэдийн чөлөөт цагаа эрүүл, аюулгүй, тохилог орчинд зөв боловсон өнгөрөөх орчин бий болгох, ногоон байгууламжийг бий болгосноор Эрдэнэт голын эх үүсвэрийг хамгаалах, хүрээлэнгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлан хамгаалах, нөхөн сэргээх, мод бут сөөгний тарьц суулгаж нийлүүлэх, нутагшуулах, энэ чиглэлийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, учирсан хохирлыг тогтоох, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах, тусламж үзүүлэхэд оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ногоон цэцэрлэгт хүрээлэн бий болгох, мод цэцэг үржүүлэн ногоон байгууламжийн нөөц бүрдүүлэх,
- Олон нийтийн амрах, зугаалах, биеийн тамирыг хөгжүүлэх, эрүүл мэндийг дэмжсэн орчин нөхцөлийг бүрдүүлсэн бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэх, гүйцэтгэлд хяналт тавих,
- Ногоон байгууламжийг арчлах, нөхөн сэргээх, шинээр ургуулах, иргэдэд зориулсан техник хэрэгслэлийг засварлах, сэргээх, байнгын ажиллагаанд бэлэн байлгах,
- Иргэд, олон нийтийн амралт чөлөөт цаг, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйлчилгээ үзүүлэн зохион байгуулах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Улсын төсөвт үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 38 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4-д “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг аймгийн Засаг дарга томилдог байна.

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа нь удирдлагын цалин, урамшууллыг 784.6 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараахь нөхцөлийг тусгана”, 19.1.8-д “цалин, нэмэгдэл хөлс, энэ хуульд заасан урамшуулал”, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно.

Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал /цүнх, календарь, мэндчилгээ г.м/-ын зардлыг гаргахгүй байх” гэсэн заалтын дагуу Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн ашиглалтын өмнөх захиргаа нь батлагдсан төсвийг 8,029.2 мянган төгрөгөөр хэмнэж, чиг үүргийн давхардалгүй, бүтцийн өөрчлөлтгүй, цалин хөлсийг нэмэгдүүлэлгүй ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өөрчлөлт орсон.
- Татварын хууль тогтоомж
- Нийгмийн даатгалын тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТХууль тогтоомжид өөрчлөлт орсон байна.

#### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10.5	13.1	2.6
БХХО			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	2,195.3	7,715.9	5,520.6
Үндсэн хөрөнгө	3,834,560.8	4,631,169.5	796,608.7
Биет бус хөрөнгө	1,200.0	1,200.0	0
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>3,680,293.4</b>	<b>4,231,370.5</b>	<b>551,077.1</b>
Өр төлбөрийн дүн			
Богино хугацаат өглөг			
Урт хугацаат өглөг			
Эздийн өмч			
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,830,833.8</b>	<b>4,231,370.5</b>	<b>400,536.7</b>

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 13.1 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 7,715.9 мянган төгрөг болж 5,520.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд тусгай зориулалтын материал бэлтгэснээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Оны эцэст 3,146.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан ч бараа материалын нөөц үүсээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Тайлант онд 900.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, дуусаагүй барилга, аймгийн Засаг даргын шийдвэрээр 162,857.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авч, 672,222.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, нийт 835,980.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс аймгийн Засаг даргын 2021 оны А/165 дугаар захирамжаар нийт 39,371.9 мянган төгрөгийн өртөгтэй, 2,296.7 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 1 ширхэг хөрөнгийг акталжээ.

Биет бус хөрөнгө 1,200.0 мянган төгрөгийн санхүүгийн программ хангамж бүртгэлтэй байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 4,632,369.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг байгууллага ашиглаж байгаа нь санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангаж байна.

Дуусаагүй барилга данс үлдэгдэлгүй байна.

Богино хугацаат болон урт хугацаат өр төлбөр данс үлдэгдэлгүй байна.

Шалгагдагч байгууллага Хөгжлийн банкнаас зээл аваагүй байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үндсэн үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад үндсэн үйл ажиллагааны зардал 89,869.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагын үйл ажиллагаа тогтворжсонтой холбоотой байна.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны 2021 оны үйл ажиллагааны санхүүжилт орон нутгийн төсөл хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлдэг байна. Санхүүжилтийн хуваарийг аймгийн СТСХ боловсруулж, аймгийн Засаг дарга баталдаг байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсөл хөтөлбөрөөс үйл ажиллагааны санхүүжилт 171,379.9 мянган төгрөг, орон нутгийн хөрөнгөөс оруулалтаас автомашины засварт 3,537.0 мянган төгрөг, нийт 174,916.8 мянган төгрөг төвлөрч, 442,796.2 мянган төгрөгийн зардал гарган, 267,876.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орон нутгийн төсөл хөтөлбөрөөс төвлөрсөн орлогын гүйцэтгэл 171,379.9 мянган төгрөг болж төлөвлөснөөс 8,029.2 мянган төгрөг буюу 4.5 хувиар тасарсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, тогтмол зардлыг оны эцэст хэмнэлттэй байхаар тооцоолж санхүүжилтийг хасаж олгосонтой холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 442,796.2 мянган төгрөг байгаа нь үйл ажиллагааны зардалд 171,379.9 мянган төгрөгийг зарцуулж, хөрөнгийн элэгдлийн зардал 237,224.7 мянган төгрөг байна. Үйл ажиллагааны зардал төлөвлөснөөс 8,029.2 мянган төгрөг буюу 4.5 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь санхүүжилт дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээ төлөвлөөгүй байна.

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн ашиглалтын өмнөх захиргаа нь ашиг алдагдлын тооцоо хийдэггүй байна.

Тайлант онд төсвөөс гадуур 3,537.0 мянган төгрөгийг автомашины засварт зарцуулсан байна.

## 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа нь тайлант онд нийт 164,588.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 100.0 мянган төгрөгийн нэг тушаал, байгууллагын бүтэц, хөрөнгө оруулалтын мэдээлэл, төсвийн гүйцэтгэлийн мэдээ зэрэг нийт 8 мэдээллийг 7, 8, 9 дүгээр саруудад хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,553.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгснөөс 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	2	3,553.3	2	3,553.3			
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>3,553.3</b>	<b>2</b>	<b>3,553.3</b>			

## **7. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## **8. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 100.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 100.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 100.0 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,918.4 мянган төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

### **8.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг ил тод байршуулахаас 100.0 мянган төгрөгийн 1 тушаал, байгууллагын бүтэц, хөрөнгө оруулалтын мэдээлэл, төсвийн гүйцэтгэлийн мэдээ зэрэг нийт 8 мэдээллийг 7, 8, 9 дүгээр саруудад хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

